



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 6 сарын 26 өдөр

Дугаар 175

Улаанбаатар хот


Тогтоолууд хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.2.3, 6.2.4, Даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны “Даатгалын нягтлан бодох бүртгэлийн дансны заавар” батлах тухай 2007 оны 189 дүгээр тогтоол, “Малын индексжүүлсэн даатгалыг санхүүгийн нэмэлт тайланд бүртгэх, тайлагнах түр заавар” батлах тухай 2011 оны 177 дугаар тогтоол, “Даатгуулагчдад сугалаа, бэлэг, урамшуулал олгохыг хориглох тухай” 2012 оны 361 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болгосугай.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН